

**“ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

№	ХУУЛИЙН НЭР	ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТ
1.	<u>БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2002-12-12 Дагаж мөрдөх огноо: 2003-02-01</i>	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.9. “банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд” гэж энэ хуулийн 6.1.-д заасан этгээдийг; 6 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх 6.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд эрхэлж болно. 7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа 7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно: 7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах; 7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; 8 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг 8.1. Энэ хуулийн 7.1.-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн этгээд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.-д заасан болон дараахь баримт бичгийг бүрдүүлж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ: 9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 9.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хүсч, ирүүлсэн баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо хүлээн авч ажлын 30 хоногийн дотор хянаад, дараахь шаардлагыг хангасан тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно: 12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл 12.1. Банк бус санхүүгийн байгууллага дараахь үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно: 12.1.1. тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхлэх; 14 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө 14.1. Банк бус санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөтэй байна. Өөрийн хөрөнгийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу тодорхойлно. 14.2. Дүрмийн сан нь банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханшийн

		өөрчлөлт, банк бус санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Санхүүгийн зохицуулах хороо тогтооно. 14.5. Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах бүрд Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж зөвшөөрөл авна. 14.6. Дүрмийн санг нэмэгдүүлэх, хорогдуулах шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журмыг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно. 18 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах нөхцөл 18.1. Банк бус санхүүгийн байгууллагыг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно. 18.2. Банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай зөвшөөрөл авахад дор дурдсан баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд гаргаж өгнө: 18.3. Санхүүгийн зохицуулах хороо баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай холбогдох асуудлыг шийдвэрлэж нийтэд мэдээлнэ. 18.4. Банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хууль тогтоомж зөрчсөн, харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл өгөхөөс татгалзана. 18.5. Банк бус санхүүгийн байгууллагыг татан буулгах тухай Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг үндэслэн хууль тогтоомжид заасан журмын дагуу банк бус санхүүгийн байгууллагыг татан буулгана. 19 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт 19.1. Санхүүгийн зохицуулах хороо энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хяналт тавьж, шалгалт хийнэ. 19.2. Банк бус санхүүгийн байгууллага нь хяналт шалгалтаар энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг зөрчсөн нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Санхүүгийн зохицуулах хороо дор дурдсан арга хэмжээ авна:
2.	<u>АЖ АХУЙН ҮЙЛ</u> <u>АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ</u> <u>ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2001-02-01</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2002-01-01</i>	15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл 15.1. Энэ зүйлд заасан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ. 15.2. Банкны үйл ажиллагааны чиглэлээр: 15.2.1. Банк байгуулах, банкны үйл ажиллагаа эрхлэх. 15.3. Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр: 15.3.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх; 15.3.2. арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх; 15.3.3. даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх; 15.3.4. банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх;

		15.3.5.үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх. 15.3.6.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах; 15.3.7.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх; 15.3.8.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх. 15.3.9.зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх.
3.	<u>НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2015-07-09</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2016-01-01</i>	13 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх 13.5.Дараах үйлчилгээг албан татвараас чөлөөлнө: 13.5.1.валют солих үйлчилгээ; 13.5.2.мөнгө хүлээн авах, шилжүүлэх, баталгаа, төлбөрийн нэхэмжлэл гаргах, вексель, хадгаламжийн данстай холбогдсон <u>банкны үйлчилгээ</u>; 13.5.3.зээл олгох үйлчилгээ; 13.5.7.<u>банкны болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны</u> зээлийн хүү, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.4-т заасан хүү, 10.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл, санхүүгийн түрээсийн хүү, ногдол ашиг, зээлийн баталгааны хураамж, даатгалын гэрээний хураамж төлөх үйлчилгээ;

“БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ХЯНАХ, ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ

№	ХУУЛИЙН НЭР	ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТ
1.	<u>БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2002-12-12</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2003-02-01</i>	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.5 “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкин дахь өөрийн харилцах дансаар дамжуулан шилжүүлэх, эсхүл интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог нь гүйцэтгэх ажиллагааг; 7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа 7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараахь үйл ажиллагааг ойлгоно: 7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах; 7.1.6. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;
2.	<u>БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2013-01-10</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2013-01-10</i>	2 дугаар зүйл. Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж 2.1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай, Банкны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
3.	<u>БАНКНЫ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга)</u> <i>Батлагдсан огноо: 2010-01-28</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2010-01-28</i>	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“банк” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг; 6 дугаар зүйл. Банкны эрхлэх үйл ажиллагаа 6.1.Банк Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 6.1.8.гадаад төлбөр тооцоо хийх;
4.	<u>ВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 1994-05-12</i> <i>Дагаж мөрдөх огноо: 1994-06-01</i>	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо 2. "Үндэсний валют" гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. 3. "Гадаад валют" гэж эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэмдэгт, тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл

		хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр чөлөөтэй хөрвөдөг. 14 дүгээр зүйл. Гадаад валютын зээл, төлбөр тооцоо 1. Гадаад орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас Засгийн газрын шугамаар авсан гадаад зээл тусламжийн нэгдсэн бүртгэлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөтөлнө. 8. Сангийн яам нь Засгийн газрын валютын гүйлгээ, гадаад төлбөр тооцоог банкаар дамжуулан хийнэ.
5.	<u>ВЕКСЕЛИЙН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 1995-11-02</i> <i>Дагаж мөрдөх огноо: 1995-11-02</i>	9 дүгээр зүйл. Векселийн төлбөрийг гүйцэтгэх 4. Вексель эзэмшигч төлбөрийг вексельд заасан төлбөрийн хугацаанд банкаар дамжуулан нэхэмжилж болно. Банк төлбөр гүйцэтгэсний /үйлчилгээ үзүүлсний/ шимтгэлийг авч болно. Векселиэр төлбөр тооцоо гүйцэтгэх журмыг Сангийн яам, Монголбанк тогтооно.
6.	<u>ГААЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2008-05-20</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2008-07-01</i>	271¹ дүгээр зүйл. Гаалийн байгууллагын удирдлагын бүрэн эрх 271¹.1.15.гадаад худалдааны төлбөр тооцоонд гаалийн зорилгоор хяналт тавих;
7.	<u>ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2002-05-30</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2002-06-01</i>	7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа 7.3.Дараахь зүйлийн талаар хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгааг бодит байдалд үл нийцсэнд тооцно: 7.3.4.төлбөр тооцооны нэмэлт нөхцөл;
8.	<u>ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2017-05-11</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2017-07-01</i>	11.29 дүгээр зүйл.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих 13.Хуульд заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь гадаад гуйвуулга, шилжүүлэг, төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банктай корреспондент харилцаа тогтоохоос өмнө хуульд заасны дагуу мэдээллийг авах үүргээ биелүүлээгүйн улмаас уг дутагдлыг арилгах талаар хянан шалгагчийн өгсөн үүрэг, даалгавар, шаардлагыг биелүүлээгүй бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 11.30 дугаар зүйл.Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль зөрчих 1.Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгслэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулахаас бусад тохиолдолд: 1.1.бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэх, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх үүргээ биелүүлээгүй; 1.2.Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоосон, эсхүл төлбөр тооцоо гүйцэтгэсэн, эсхүл зарлан сурталчилсан бол тухайн үйл ажиллагаанаас олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9.	<u>ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ</u> <u>ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2017-05-18</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2017-07-01</i>	1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Зөрчлийн тухай хууль баталсантай холбогдуулан баталсан Автозамын тухай хуульд өөрчлөлт

		Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,....
10.	<u>ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2012-02-10</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2012-02-10</i>	5 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 5.1.3. “зээлийн батлан даалт” гэж Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасныг;
11.	<u>ИРГЭНИЙ ХУУЛЬ</u> <i>Батлагдсан огноо: 2002-01-10</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2002-02-05</i>	445 дугаар зүйл. Төлбөр тооцооны гэрээ 445.1. Төлбөр тооцооны гэрээгээр банк, эрх бүхий бусад хуулийн этгээд /цаашид “төлбөр тооцоо гүйцэтгэгч” гэх/ нь иргэн болон хуулийн этгээд /цаашид “харилцагч” гэх/-ийн бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээнэ. 445.2. Хуульд өөрөөр заагаагүй бол бэлнээр хийх төлбөр тооцоог банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэж болно. 445.3. Бэлэн бусаар хийх төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр гүйцэтгэж болно. 445.4. Төлбөр тооцоо гүйцэтгэгч нь харилцагчийн өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог гүйцэтгэнэ. 445.5. Хуульд өөрөөр заагаагүй бол дансан дахь мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах харилцагчийн эрхийг төлбөр тооцоо гүйцэтгэгч хязгаарлах, хянах эрхгүй. 445.6. Банк, эрх бүхий хуулийн этгээд нь харилцагчийн төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалгах эрхтэй. 445.7. Төлбөр тооцооны гэрээгээр талууд төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний хөлс төлөхөөр тохиролцож болно. 445.8. Банк, төлбөр тооцоо хийх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хийх төлбөр тооцооны харилцааг хуулиар зохицуулна. 446 дугаар зүйл. Төлбөр тооцоо гүйцэтгэгчийн үүрэг 446.1. Төлбөр тооцоо гүйцэтгэгч дараахь үүрэгтэй: 446.1.1. бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэлийг хөтлөх; 446.1.2. гэрээнд заасан хугацаанд харилцагчид түүний дансны талаар мэдээлэл, дансны хуулга өгөх; 446.1.3. харилцагчийн данснаас түүний өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гүйлгээ хийх; 446.1.4. хуульд зааснаас бусад тохиолдолд данс, гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх; 446.1.5. алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн гүйлгээг залруулж, харилцагчийг хохиролгүй болгох; 446.1.6. харилцагчийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх; 446.1.7. хуульд заасан бусад үүрэг. 447 дугаар зүйл. Харилцагчийн эрх 447.1. Харилцагч дараахь эрхтэй: 447.1.1. өөрийн данс, гүйлгээний талаархи мэдээллийг хэдийд ч авах; 447.1.2. мөнгөн төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах; 447.1.3. хуульд заасан бусад эрх.

		447.2.Энэ хуулийн 447.1.2-т заасан тохиолдолд харилцагч нь төлбөр тооцоо гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх бөгөөд төлбөр тооцоо гүйцэтгэгч нь төлбөрийн даалгаварт заасан мөнгийг харилцагчийн дансанд буцаан оруулна. 448 дугаар зүйл. Төлбөр тооцооны гэрээг цуцлах 448.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол талууд төлбөр тооцооны гэрээг хэдийд ч харилцан тохиролцож цуцалж болно. 49 дүгээр зүйл. Аккредитив 449.3.Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална. 450 дугаар зүйл. Инкасс 450.1.Инкассийн төлбөр тооцоогоор төлбөр тооцоо гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн өгсөн даалгаврын дагуу, түүний зардлаар, төлбөр хариуцагчаас төлбөрийг хүлээн авах буюу төлбөр хийх үүрэг хүлээнэ. 450.2.Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.
12.	<u>ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ</u> Батлагдсан огноо: 2016-02-05 Дагаж мөрдөх огноо: 2017-01-01	25 дугаар зүйл. Корпорацийн гүйцэтгэх удирдлага 25.13.Гүйцэтгэх удирдлага дараахь үндсэн эрх, үүрэгтэй байна: 25.13.3.санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой санхүү бүртгэл, мэдээлэл, удирдлага, зохион байгуулалтын асуудлаар холбогдох шийдвэрийг гаргах;
13.	<u>МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> Батлагдсан огноо: 2017-02-10 Дагаж мөрдөх огноо: 2017-04-01	8 дугаар зүйл. Хөгжлийн банкны үйл ажиллагааны хүрээ 8.1.Хөгжлийн банк дараахь үйл ажиллагаа эрхэлнэ: 8.1.1.төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх; 8.1.2.төлбөр тооцоо хийх; 11 дүгээр зүйл. Төлбөр тооцоо хийх 11.1.Хөгжлийн банкны төлбөр тооцооны үйл ажиллагааг Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу зохицуулна. 11.2.Төлбөр тооцооны үйлчилгээний хөлсийг Хөгжлийн банк тогтооно. 21.5.Гүйцэтгэх удирдлага Компанийн тухай хуульд зааснаас гадна дараахь эрхийг хэрэгжүүлнэ: 21.5.1.хуульд төлөөлөн удирдах зөвлөл батлахаар зааснаас бусад Хөгжлийн банкны дотоод дүрэм, журам, заавар, аргачлал болон хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлийг батлах; 21.5.2.санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх, төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой санхүү бүртгэл, мэдээлэл, удирдлага, зохион байгуулалтын асуудлаар шийдвэр гаргах; 31 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 31.1.Хөгжлийн банкны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд шүүгч, эсхүл холбогдох улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна: 31.1.3.төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан ажилтан, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;
14.	<u>МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> Батлагдсан огноо: 2013-05-31	3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 3.1.3.“бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглаж хийсэн гүйлгээг;

	Дагаж мөрдөх огноо: 2013-05-31	3.1.4. “бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг; 5 дугаар зүйл. Харилцагчийг таньж мэдэх 5.6. Энэ хуулийн 4.1.1-д заасан этгээд нь гадаад гуйвуулга, шилжүүлэг, төлбөр тооцоо хийх зорилгоор гадаад улсын банктай корреспондент харилцаа тогтоохоос өмнө дараах мэдээллийг авсан байна:
15.	НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ Батлагдсан огноо: 1995-05-11 Дагаж мөрдөх огноо: 1995-05-11	17 дугаар зүйл. Харилцагчдын үүрэг 1. Хуульд өөрөөр заагаагүй бол татан буугдаж байгаа нөхөрлөлтэй харилцагчид татан буугдах гэж байгааг нийтэд мэдээлснээс хойш 3 сарын дотор төлбөр тооцоогоо хийх үүрэгтэй. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд харилцагч тал төлбөр, тооцоогоо хийгээгүй бол нэхэмжлэл хангуулах эрхээ алдана.
16.	НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/ Батлагдсан огноо: 2015-07-09 Дагаж мөрдөх огноо: 2016-01-01	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.9. “гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр авсан бараа” гэж давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгахад зориулсан, түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хариу төлбөргүйгээр хүлээн авсан барааг. Үүнд буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагаас мөнгөөр өгсөн санхүүжилтээр дотоодын зах зээлээс худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээ мөн хамаарна; 4.1.10. “төлбөр тооцоо хийх” гэж бэлэн ба бэлэн бусаар төлбөр тооцоо хийхийг; 4.1.11. “нэгдсэн систем хариуцагч” гэж Монгол Улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний цахим баримтын мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг; 4.1.12. “хэрэглэгчийн систем нийлүүлэгч” гэж Монгол Улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйл ажиллагаанд зориулсан бүртгэл, төлбөр тооцооны бүрэлдэхүүн хэсэг, нэгдсэн системтэй холбогдон ажиллах баталгаажсан тоног төхөөрөмж болон системийг нийлүүлэх хуулийн этгээдийг; 4.1.13. “нэмэгдсэн өртгийн албан татварын падаан” гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг;

		4.1.14."төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг; 4.1.15."дахин давтагдашгүй төлбөрийн дугаар" гэж худалдаа, үйлчилгээ эрхлэгч албан татвар суутган төлөгчийн татвар төлөгчийн дугаар, салбар, төлөөлөгчийн газартай бол салбарын дугаар, төлбөр тооцооны он, сар, өдөр, төлбөр тооцооны дэс дугаарыг дунд нь ямар нэг тэмдэгт хэрэглэлгүйгээр үргэлжлүүлэн тоон утгаар илэрхийлсэн дугаарыг; 4.1.16."бүртгэлийн хэрэгсэл" гэж бараа, ажил, үйлчилгээг худалдан авч, төлбөр төлж, борлуулалт хийснийг нотлох зориулалт бүхий төлбөрийн баримтын мэдээллийг агуулсан тусгай таних тэмдэг бүхий эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан төлбөр, төлбөрийн карт болон түүнтэй адилтгах мэдээлэл хадгалах, дамжуулах боломж бүхий бүх төрлийн төлбөр тооцооны бүртгэлийн хэрэгслийг; 4.1.17."бүртгэлийн машин" гэж албан татвар суутган төлөгчийн борлуулалтыг төлбөрийн баримтад заагдсаны дагуу бүртгэж, бүртгэлийн мэдээллийг төлбөр тооцооны бүртгэлийн системд дамжуулах тусгай зориулалт бүхий кассын машин, түүний салшгүй хэсэг болсон пос терминал буюу түүнтэй адилтгах программ хангамж бүхий тоног төхөөрөмжийг; 4.1.21."хэрэглэгчийн систем" гэж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа этгээдэд зориулсан бараа, агуулах, борлуулалтын бүртгэл, төлбөр тооцооны бүрэлдэхүүн хэсэг, бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн системтэй холбогдон ажиллах баталгаажсан тоног төхөөрөмж болон системийг. 15 дугаар зүйл.Албан татварыг буцаан олгох 15.10.Энэ хуулийн 15.2.1-д заасан буцаан олгох татварын хэмжээг төлбөр тооцооны хэлбэрээс хамааруулж, 15.2.2-т заасан урамшууллын хэлбэр, түүнийг явуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 17 дугаар зүйл.Нэгдсэн ба хэрэглэгчийн систем 17.3.Албан татвар суутган төлөгч доор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 17.3.1.албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ;
17.	<u>НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2015-06-19</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2016-01-01</i>	12 дугаар зүйл.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого 12.1.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна. 12.2.Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; 12.2.3.эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед; 12.2.4.гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртсөний дараа; <u>/Энэ заалтад 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u>

		12.2.5.аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэр гарсан, дампуурлын хэрэг үүсгэсэн үед; 12.2.6.хуульд заасан бусад тохиолдолд. 12.3.Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ. 20 дугаар зүйл.Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 20.2.Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.1.энэ хуулийн 17.1-д заасан эрх бүхий этгээдийн хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх; 20.2.2.аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах; 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; 20.2.7.аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах;
18.	<u>ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ</u> Батлагдсан огноо: 1996-10-25 Дагаж мөрдөх огноо: 1996-10-25	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 7/ "хуулийн этгээдийн эзэмшлийн орон сууц" гэж тухайн хуулийн этгээдийн тайлан, балансад бүртгэлтэй, түүний ашиглалт, засвар, үйлчилгээний бүх зардал болон сууц эзэмшигчидтэй хийх гэрээ, төлбөр тооцоог уг хуулийн этгээд нь бүрэн хариуцан гүйцэтгэдэг орон сууцыг.
19.	<u>ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ</u> Батлагдсан огноо: 2015-02-18 Дагаж мөрдөх огноо: 2015-02-18	40 дүгээр зүйл.Өрийн бүртгэл 40.3.Засгийн газрын үнэт цаасыг төлбөр тооцоо хийгдсэн өдрөөр нь өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, ерд бүртгэнэ.
20.	<u>СОНГУУЛИЙН ТУХАЙ</u> Батлагдсан огноо: 2015-12-25 Дагаж мөрдөх огноо: 2015-12-25	42 дугаар зүйл.Сонгуулийн зардлын зарцуулалт 42.1.Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг сонгуулийн зардалд зориулан бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны хэлбэрээр зарцуулна.
21.	<u>ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ</u> <u>/Шинэчилсэн найруулга/</u> Батлагдсан огноо: 2019-03-22 Дагаж мөрдөх огноо: 2020-01-01	18 дугаар зүйл.Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам 18.1.Энэ зүйлд заасан дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 18.1.2.в.хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьд хувьцаа, хувь оролцоо, нэгж эрх болон бусад ашиг сонирхлын тухай мэдээллийг, итгэлцлийн сангийн хувьд төлбөр тооцоо

		гүйцэтгэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, болон өгөөж хүртэж байгаа этгээдийн талаарх мэдээллийг. 29 дүгээр зүйл.Татварын тайлан үйлдэх, тушаах 29.1.Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ: 29.1.6.татварын тайланд тусгах, бүртгэх төлбөр тооцоо гадаад валютаар хийгдсэн тохиолдолд тухайн гүйлгээ хийсэн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож төгрөгөөр илэрхийлэх. 34 дүгээр зүйл.Бусад байгууллагаас мэдээлэл гаргуулах, хамтран ажиллах 34.14.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дараах мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ: 34.14.1.үнэт цаасны бүртгэл, өөрчлөлтийн болон төлбөр тооцооны мэдээлэл; 62 дугаар зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаас битүүмжлэх, бэлэн мөнгө хураах, татварын өр гаргуулах 62.10.Татварын улсын байцаагч үнэт цаасыг битүүмжлэх актыг тухайн үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд хүргүүлж гүйцэтгэнэ.
22.	<u>ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 1996-09-03</i> <i>Дагаж мөрдөх огноо: 1996-10-01</i>	8 дугаар зүйл. Төлбөрийн хууль ёсны хэрэгсэл 1. Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төгрөг нь өөрийн нэрлэсэн дүнгээрээ Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх төлбөр тооцоонд хэрэглэгдэх төлбөрийн хууль ёсны хэрэгсэл мөн. 2.Төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр төлбөр тооцоонд хэрэглэнэ. 17 дугаар зүйл. Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх Монголбанк Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхдээ дараахь үйл ажиллагааг явуулж болно: 1/зохих нөхцөлийг тусгасан гэрээний дагуу төрийн сангийн нэгдсэн дансыг Сангийн сайдын хүсэлтээр өөр дээрээ байршуулж, Засгийн газрын төлбөр, түүнтэй холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэх; 3/ Засгийн газрын болон түүнээс баталгаа гаргасан хуулийн этгээдийн гадаадаас авсан зээлийн төлбөрийн хуваарийг баримтлан төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдлийн хэмжээнд багтаан төлбөр тооцоо гүйцэтгэх; 21 дүгээр зүйл. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж, удирдах 5. Гадаад валютын улсын нөөц нь Улсын Их Хурлаас тогтоосон доод хэмжээнээс багассан эсхүл гадаад валютын бодлогыг хэрэгжүүлэх болон улсын гадаад төлбөр тооцоог шүүрхай явуулах боломж алдагдсаныг Монголбанк тодорхойлсон нөхцөлд Монголбанк Засгийн газартай хамтран холбогдох арга хэмжээ авна. 23 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагаанд хориглох зүйл 1. Монголбанкнаас дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 3/Засгийн газар болон банк, Хадгаламжийн даатгалын болон Ирээдүйн өв сан корпораци, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шууд оролцогч, оператороос бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэх; 2. Монголбанк дараахь үйл ажиллагаа явуулах нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасанд хамаарахгүй:

		4/ банкны төлбөрийн чадварт гарсан хүндрэл нь банкны тогтолцоо, төлбөр тооцооны тогтолцооны шинж чанартай эрсдлийг үүсгэж болзошгүй болсон гэж үзэж Монголбанк онцгой дэглэм тогтоосон. 25 дугаар зүйл. Монголбанкны хянан шалгагчийн бүрэн эрх 1. Монголбанкны хянан шалгагч банкны тухай хууль тогтоомж, төрийн мөнгөний бодлого болон Монголбанкны гаргасан дүрэм, журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн шийдвэрийг иргэн, хуулийн этгээд банкнаас хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, шалгалт хийнэ. Хянан шалгагч нь улсын байцаагчийн эрх эдэлнэ. 2. Монголбанкны хянан шалгагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгчийн болон банкны байр, тасалгаа, бусад холбогдох газарт нэвтрэн орох; 2/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банкны данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримт, тоног төхөөрөмж, шаардлагатай бусад зүйлд хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах, асуулт тавьж, хариулт авах; 3/шаардлагатай магадлагаа, баримтын хуулбарыг төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банкны харилцагч, хэрэглэгч, иргэн, хуулийн этгээд, банк, санхүүгийн болон бусад байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах; 4/ хуулийн этгээд, иргэний банкны үйл ажиллагаатай холбогдох баримтыг шалгаж үзэх; 5/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банк, түүний үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэх; 6/ хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх; 7/ Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй буюу зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах санг бүрэн байгуулаагүй банкны гишүүнд ногдол ашиг хуваарилахыг зогсоох. 8/үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, гэрээт төлөөлөгч, банкны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, программ хангамжид нэвтрэх, тэдгээрээс банкны үйл ажиллагаатай холбоотой тайлан мэдээ, мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр хувилан авах. 25² дугаар зүйл. Монголбанкны хянан шалгагч, хянагчийн хяналт шалгалт хийхээс татгалзах үндэслэл 1. Монголбанкнаас томилсон хянан шалгагч, хянагч нь дараахь нөхцөлд хяналт шалгалт хийхээс татгалзана:
--	--	--

		1/үндэсний төлбөрийн системийн тухайн оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, тэдгээрт аутсорсингийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, төлбөр тооцооны төлөөлөгч, банканд сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаж байсан;
23.	<u>ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2009-07-09</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2009-07-09</i>	4 дүгээр зүйл.Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ 4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно. 4.2.Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.
24.	<u>ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2005-12-01</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2006-02-01</i>	28 дугаар зүйл.Тендерийг үнэлэх 28.13.Тендерийн баримт бичигт зааснаас өөр гадаад валютыг төлбөр тооцоонд хэрэглэх бол түүнийг хөрвүүлэх ханшийг тендер зарласан өдөр Монголбанкнаас зарласан ханшаар тооцно.
25.	<u>ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2010-06-24</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2010-06-24</i>	17 дугаар зүйл.Санхүүгийн хуримтлал, түүний хөрөнгө оруулалт 17.4.Хөрөнгө оруулах шийдвэрийг гаргах үед зээл авах нөхцөл, шаардлага үүсээгүй, зөвхөн Сангаас хөрөнгө оруулахаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, тухайн хэрэгсэлд хөрөнгө оруулах төлбөр тооцоог гүйцэтгэхэд дутагдаж байгаа богино хугацааны эх үүсвэрийн дутагдлыг бүрдүүлэх зорилгоор зээл авч болно.
26.	<u>ТӨСВИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2011-12-23</i> <i>Дагаж мөрдөх огноо: 0000-00-00</i>	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 4.1.40.“төрийн сангийн үйл ажиллагаа” гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг;
27.	<u>УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2010-11-25</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2011-01-01</i>	17 дугаар зүйл.Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ 17.1.Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 17.1.9.гадаад төлбөр тооцоо хийх тусгай зөвшөөрөл олгоход 180 000-450 000 төгрөг;
28.	<u>ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМНИЙ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2017-05-31</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2018-01-01</i>	5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 5.1.27.“төлбөр тооцооны данс” гэж оролцогч хооронд төлбөр тооцоо хийхэд ашиглах Монголбанк, арилжааны төлбөр тооцоог төвлөрүүлэн гүйцэтгэх эрх бүхий этгээд, эсхүл төлбөр тооцооны төлөөлөгч дээр байршиж байгаа оролцогчийн дансыг; 5.1.28.“клиринг” гэж төлбөр тооцоо хийхээс өмнө мөнгөн хөрөнгийн, эсхүл үнэт цаасны шилжүүлгийн даалгаврыг дамжуулах, тохируулах, баталгаажуулах үйл явц бөгөөд үүнд шилжүүлгийн үр дүнгийн тооцоолол, төлбөр тооцооны эцсийн дүнг тодорхойлох ажиллагаа багтана;

29.	<u>ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2017-05-31</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2018-01-01</i>	1 дүгээр зүйл.Засгийн газрын төлбөр, түүнтэй холбогдох төлбөр тооцоог Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гүйцэтгэх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгогдсонд тооцно.
30.	<u>ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2013-05-24</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2014-01-01</i>	36 дугаар зүйл.Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа 36.9.Энэ хуулийн 36.8-д заасан харилцагчийн мөнгөн хөрөнгө үнэт цаасыг хадгалах данс нь зөвхөн үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх зорилго бүхий үнэт цаасны арилжааны данс байна. 36.10.Энэ хуулийн 36.8-д заасны дагуу харилцагчийн мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг хадгалах дансан дахь мөнгөн хөрөнгийг харилцагч болон түүнээс олгосон итгэмжлэл бүхий этгээдээс бусад этгээд үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэхээс бусад зорилгоор захиран зарцуулахыг хориглоно.
31.	<u>ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2011-10-06</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2012-01-01</i>	13 дугаар зүйл.Гэрээ 13.1.Хангагч, хэрэглэгчийн хоорондын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг энэ хууль, цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ /цаашид "гэрээ" гэх/-гээр зохицуулна. 13.2.Хангагч нь Зохицуулах зөвлөлийн баталсан аж ахуйн харилцааны дүрмийн дагуу хэрэглэгчтэй гэрээ байгуулна. 13.3.Энэ хуулийн 13.2-т заасан гэрээнд нийлүүлэх цэвэр ус болон татан зайлуулах бохир усны хэмжээ, чанар, найрлага, гэрээг дүгнэх хугацаа, төлбөр тооцооны арга, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хохирол тооцох журам болон шаардлагатай бусад зүйлийг тусгана.
32.	<u>ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2011-10-27</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2011-11-05</i>	2 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж 2.1.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 25 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний эрх нь дуусгавар болсон этгээдтэй тооцоо хийх 25.1.Гишүүний эрх нь дуусгавар болсон, дуусгавар болсонд тооцогдсон гишүүнтэй хийх оруулсан хувь хөрөнгөтэй холбоотой төлбөр тооцооноос бусад өр төлбөрийн тооцоог тухайн гишүүний эрх нь дуусгавар болсон буюу дуусгавар болсонд тооцогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хийж гүйцэтгэнэ. 45 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны идэвхгүй гишүүний хөрөнгө 45.6.Идэвхгүй гишүүнтэй хийх төлбөр тооцоог энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.
33.	<u>ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ</u> <i>Батлагдсан огноо: 2011-06-02</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2012-06-01</i>	5 дугаар зүйл.Биржийн чиг үүрэг 5.2.Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан дор дурдсан журмыг энэ хуулийн 8.1-д заасан Биржийн зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, мөрдүүлнэ: 5.2.7.биржийн арилжааны төлбөр тооцоо хийх; 6 дугаар зүйл.Биржийн төлбөр тооцоо, хадгаламж 6.1.Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг

		гэрээний үндсэн дээр банк, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэх, эсхүл уг үүргийг гүйцэтгэх түсгайлсан нэгж /цаашид “төлбөр тооцооны төв” гэх/-тэй байна. 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төлбөр тооцооны төв нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42, 44, 45 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй: 6.2.1.талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүйгээс гарах хохирлын хэмжээг тодорхойлох; 6.2.2.гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгүүлэх; 6.2.3.энэ хуулийн 6.2.2-т заасан үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор төлбөр тооцооны эрсдэлийг зохицуулах;
34.	<u>ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2017-06-09</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2017-07-01</i>	50 дугаар зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх 50.8.Энэ зүйлд заасан журам нь үнэт цаас арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд дэх данс, бусдын нэр дээр бүртгэлтэй боловч захиран зарцуулах эрхийг төлбөр төлөгч хэрэгжүүлж байгаа бусад дансанд нэгэн адил хамаарна. 50.9.Төлбөр төлөгч өөр эх үүсвэрээс төлбөр төлөх боломжгүй нь тогтоогдсон тохиолдолд татвар, нийгмийн даатгалын байгууллагаас баталгаажуулсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлбөр төлөгчийн энэ зүйлд заасан битүүмжлэгдсэн мөнгөн хөрөнгөөс шилжүүлж болно. 51 дүгээр зүйл.Үнэт цаас битүүмжлэх 51.1.Шийдвэр гүйцэтгэгч вексель, эсхүл үнэт цаастай холбоотой аливаа эрхийг хэрэгжүүлэхийн тулд түүнийг биетээр эзэмшилдээ авах шаардлагатай бусад санхүүгийн хэрэгслийг олж илрүүлсэн даруйд хураан авч битүүмжилнэ. Биет бус үнэт цаасыг битүүмжлэх тухай шийдвэрийг тухайн үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд хүргүүлж гүйцэтгэнэ. 51.11.Үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд төлбөр төлөгчийн үнэт цаасыг битүүмжлэх тухай шийдвэрээр хязгаарлагдсан эрхийг хэрэгжүүлэх тухай төлбөр төлөгчийн аливаа шаардлагыг биелүүлэхийг хориглоно. Битүүмжлэх тухай шийдвэрийг хүлээн авмагц хязгаарлагдсан эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа гүйлгээг даруй зогсооно. 86 дугаар зүйл.Төлбөр төлөгч-иргэний мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулах 86.11.Төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх хадгаламжийн болон харилцах дансанд байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, бэлэн мөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөрийг гаргуулж болно. 95 дугаар зүйл.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн өмчлөлийн бусдын эзэмшилд байгаа мөнгөн болон бусад хөрөнгөөс төлбөр гаргуулах 95.1.Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн банкн дахь харилцах данс, хадгаламжид байгаа үнэт металл, эрдэнийн чулуу, үнэт цаас, мөнгөн хөрөнгө, түүнчлэн төлбөр төлөгчөөс бусдад, бусдаас төлбөр төлөгчид бэлэн ба бэлэн бусаар шилжүүлсэн хоорондын төлбөр тооцооны мөнгөнөөс төлбөр гаргуулж болно.

		108 дугаар зүйл.Гаргуулсан төлбөрийг олгох 108.1.Шийдвэр гүйцэтгэгч гаргуулсан төлбөрийг төлбөр авагчийн банкн дахь дансанд бэлэн бусаар шилжүүлэх, эсхүл төлбөр авагчид бэлнээр хүлээлгэн өгөх ба дансны дугаар тодорхойгүй тохиолдолд мөнгийг шийдвэр гүйцэтгэх газрын дансанд шилжүүлнэ. 108.2.Гадаадад оршин суугаа /оршин байгаа/ төлбөр авагчид төлбөрийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх газрын данснаас банкаар дамжуулан гадаад төлбөр тооцооны журмаар олгох бөгөөд шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран батална.
35.	<u>ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ</u> <u>/Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2015-02-12</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2015-02-12</i>	13 дугаар зүйл.Чөлөөт бүс дэх төлбөр тооцоог гүйцэтгэх зохицуулалт 13.1.Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэнэ. 13.2.Чөлөөт бүсэд банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.
36.	<u>ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2015-12-03</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2017-07-01</i>	17.5 дугаар зүйл.Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших 1.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгө, алдуул малыг бүсдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшсаны улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж бүсдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулсан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 18.7 дугаар зүйл.Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах 1.Үнэт цаас, цахим карт, төлбөрийн бусад хэрэгсэл, онцгой албан татварын тэмдэгт, санхүүгийн баримтыг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж хадгалсан, ашигласан, зөөвөрлөсөн, тараасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Монгол Улсад төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглаж байгаа үндэсний, гадаад улсын мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж ашигласан, хадгалсан, зөөвөрлөсөн, тараасан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
37.	<u>ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</u> <i>Батлагдсан огноо: 2015-01-29</i> <i>Дагаж мөрдөх огноо: 2015-07-01</i>	16 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын чиг үүрэг 16.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 16.1.3.даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;